



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 3 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2015 оны төсвийн хэрэгжилтийг
хангах зарим арга хэмжээний тухай

Төсвийн орлогын бүрдэлт, мөнгөн хөрөнгийн боломжит нөөцтэй уялдуулан төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах зорилгоор Өрийн удирдлагын тухай хуулийн 18.7-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах, Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулиар баталсан өмч хувьчлалын болон хувьцааны ногдол ашгийн орлогыг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн хорооны дарга Ц.Нанзаддоржид даалгасугай.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжсэн татварын өрийг 2015 онд багтаан бүрэн барагдуулах арга хэмжээ авхуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Б.Билэгт, Татварын ерөнхий газрын дарга Б.Ариунсан нарт, хуримтлагдсан татварын өр, дутуу төлөлтийг хууль тогтоомжийн дагуу бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг Татварын ерөнхий газрын дарга Б.Ариунсанд тус тус даалгасугай.

3. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2015 онд батлагдсан төсвийн эх үүсвэрт багтаан үе шаттайгаар нэмэгдүүлэх санал боловсруулж, Засгийн газарт оруулахыг Хөдөлмөрийн сайд С.Чинзориг, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт даалгасугай.

4. Төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбатад даалгасугай:

4.1. байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл болон байр ашиглалт, харуул хамгаалалттай холбоотой тогтмол зардал, хоол хүнс, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг өмнөх жилийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг үндэслэн санхүүжүүлэх;

4.2. эрүүл мэнд, онцгой байдал, хил хамгаалах болон цагдаагийн байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан хангамж, бараа, материалын бүлгийн зардлыг бүрэн санхүүжүүлж, бусад төсвийг байгууллагын хангамж, бараа, материалын бүлэгт багтах зардлын санхүүжилтийг хэсэгчлэн олгох;

4.3. бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал болон бараа, бүтээгдэхүүнтэй холбоотой бусад зардлыг гэрээ, ажлын төлөвлөгөөг нь үндэслэн хэсэгчлэн санхүүжүүлэх.

5. Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад орсон, мөн онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвийн нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт даалгасугай.

6. Улсын төсвийн зарлага, санхүүжилтийг тасралтгүй хэрэгжүүлэх, төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор 550 хүртэл тэрбум төгрөгийн богино хугацаатай зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр Монголбанкнаас авахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбатад зөвшөөрсүгэй.

7. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай:

7.1. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд заасан орлогын төлөвлөгөөг баталсан хуваарийн дагуу оны эхнээс жигд ханган биелүүлэхэд онцгой анхаарч, үйл ажиллагаагаа зохион байгуулах;

7.2. Урсгал зардлыг хэмнэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол болон энэхүү тогтоолд нийцүүлэн баталж, харьяа төсөвт байгууллагуудад мөрдүүлж ажиллах.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Сангийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ